


Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны 01 дүгээр сард хийсэн ажлын товч мэдээ

2024 оны 01 дүгээр сарын 23

Дархан-Уул аймаг

Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлөөс ирүүлсэн 2024 онд төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвийг шинээр болон, ахиулан олгох материалд дотоод аудит хийж гүйцэтгэсэн. Дотоод аудитаар нийт 18 байгууллагын 97 албан хаагчийн холбогдох материалд шалгалт хийж дотоод аудитын ажлын баримтыг тус байгууллагад хүргүүлсэн.

Сангийн яамнаас Дотоод аудитын удирдлагын мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэхтэй холбогдуулан тус системийн ашиглалтын талаар зохион байгуулсан цахим сургалтад 8 албан хаагч хамрагдлаа.



Шилэн дансны 2023 оны 04 дүгээр улирлын хэрэгжилтэд дотоод аудит хийхтэй холбогдуулан байгууллагуудад мэдээллээ хянаад улирлын тайлангаа илгээх талаар цахимаар зөвлөмж хүргэлээ. Аймгийн Засаг даргын баталсан 23-06-24-02/02 удирдамжийн дагуу Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтаны 2023 оны 4 дүгээр улирлын байдалд дотоод аудит хийж байна.

Тус албаны төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулж батлах зөвшөөрөл олгох хүсэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулсан.



Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 2-10/49 албан бичгийн дагуу тус албаны болон Статистикийн хэлтсийн албан хаагчид Өргөө багийн Өнгөт 17-р байрны үзүүрээс 1 А,Б уулзвар хүртэлх явган хүний зам 120м газрын хальтиргаа ихтэй, дагтаршиж хатуурсан цас мөсыг цэвэрлэж зам талбайг чөлөөлөн тайланг ДСЗДТГазар, Захирагчийн ажлын алба, Өргөө багт тус тус хүргэлээ.



Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу албаны Хөдөлмөрийн дотоод журам, албан томилолтоор ажиллах, цалин хөлс олгох, зайнаас ажиллах журмын төслийг боловсруулж байна. Мөн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021-2023 оны хэрэгжилтийг иргэдэд тайлагнах хүрээнд Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбогдох мэдээллийг цахимаар АЗДТГ-ын СТСХ-т хүргэлээ.

Хонгор сумын ЗДТГазраас ирүүлсэн хүсэлтийн дагуу “Хонгор хот тохижилт” ОНӨААТҮГазрын санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж байна.

Санхүүгийн хяналт шалгалт болон дотоод аудит хийхдээ ашиг сонирхлын зөрчилгүй мэдүүлгийг байгууллагын ЭБАТушаалтанд өгч байна.

2023 оны санхүүгийн тайланд аудит хийж байгаатай холбогдуулан санхүүгийн тайлан, Ерөнхий журнал гүйцэтгэлийн баримтыг цахимаар хүргүүлсэн.

Сангийн яамны Дотоод аудитын хорооны тогтоолын дагуу тус албанд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсрууллаа.

2023 оны үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтуудыг албан хаагч бүр үдэж архивын нэгж үүсгэсэн.

Засгийн газрын гишүүд, аймаг нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарын 2024 онд баримталж ажиллах үйл ажиллагааны талаарх цахим уулзалтад албаны дарга, ахлах байцаагч нар оролцлоо.

Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд зөвлөх багаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хуулийн нийцэл болон байгууллагын орчны шинжилгээний судалгааны тайланг гаргаж, процесс зураглалыг шинэчлэлээ.

Засаг даргын зөвлөлийн хурал, Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралд албаны дарга оролцлоо. Мөн төрийн албаны тусгай шалгалтын гишүүнээр ажиллалаа.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА